


“Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ын
Захирлын 2017 оны 04 дугаар сарын 14-ний
өдрийн 1/9 дугаар тушаалын хавсралт №2



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ БАЙДАЛД ТАВИХ ГУРВАН ШАТНЫ ХЯНАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1. Байгууллагын үйлдвэрлэлийн бүх тоног төхөөрөмж, барилга байгууламж, дамжлага, машин механизм, ажлын байруудад ХАБЭА-н шаардлага хэрхэн хангагдаж байгааг шалгаж, зөрчил дутагдлыг цах тухайд нь илрүүлэн арилгаж байх зорилгоор гурван шатны хяналтын ажлыг зохион байгуулахад энэ журмыг мөрдлөг болгоно.

2. Гурван шатны хяналтыг тогтоосон хугацаанд нь тогтмол явуулж байх нь байгууллагын захиргаа, албан тушаалтан нараас үйлдвэрлэл, хөдөлмөрийн аюулгүй байдал, ажлын байрны эрүүл ахуйг хангах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх үйл ажиллагааны үндсэн арга хэлбэр мөн.

Хоёр. Анхан шатны хяналт

1. Үйлдвэрлэлийн ээлж, хэлтэс алба, хэсгийн дарга инженерүүдээс тус тусын хариуцсан буюу ажиллах тоноглол, дамжлага ажлын байранд ажлын эхлэл ба явцын дунд аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн нөхцөлийн байдалд өдөр бүр хийх шалгалтыг анхан шатны хяналт гэнэ.

2. Анхан шатны хяналтаар дараах зүйлүүдийг шалгана.

- a. Ажлын байран дах эд материалын зүйлийн эмх цэгц
- b. Ажлын байр, зам гарц, талбайн гэрэлтүүлэг
- c. Цех хэсэг дэх шат тавцан, зам гарц, хайс хашлагын бүрэн бүтэн байдал
- d. Ажлын байрны ариун цэврийн байдал
- e. Машин тоног төхөөрөмжийн хөдөлгөөнт хэсгийн хаалт хашилт, аюултай газар орчны хориг тэмдгийн бүрэн бүтэн байдал
- f. Цахилгаан тоног төрөөрөмжийн газардуулга, яаралтай зогсоох хэрэгслийн бүрэн бүтэн байдал
- g. Технологийн хориг хамгаалалт, дохиоллын найдвартай бүрэн бүтэн байдал
- h. Гал эсэргүүцэх багаж хэрэгслийн бүрэн бүтэн, бэлэн байдал

- i. Тэсэрч дэлбэрэх, химийн хорт болон галын аюултай бодис, материалын ашиглалт, хадгалалтын аюулгүй байдлын хангалт, тэсрэлт дэлбэрэлт, хордолт, шаталтын нөхцөл үүсэж буй эсэх
- j. Ажиллагсдын ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн ашиглалт
- k. Ажлын багаж хэрэгслийн аюулгүйн шаардлага хангалт
- l. Аюул осолтой ажил гүйцэтгэх наряд, зөвшөөрлийн бүрдүүлэлт

3. Анхан шатны хяналт хийсэн тухай тэмдэглэлийг аюулгүй ажиллагааны журналд тэмдэглэнэ.

4. Илэрсэн зөрчлийг тухай бүрт арилгуулах арга хэмжээ авч шийдвэрлэнэ.

Гурав. Хоёр дахь шатны хяналт

1. Үйлдвэрлэлийн хэлтэс алба, хэсэг буюу алба, хэсгийн дарга, инженерүүд, ХАБЭА-н ажилтан хамтран, удирдсан хэлтэс алба, хэсгийнхээ хэмжээнд ХАБЭА-н байдалд тодорхой зохион байгуулалт, хөтөлбөртэйгээр улирал бүр хийх нарийвчилсан шалгалтыг хоёр дахь шатны хяналт гэнэ.

2. Хоёрдахь шатны хяналтаар дараах зүйлүүдийг шалгана. Үүнд:

- a. Хэлтэс алба хэсгийн үйлдвэрлэлийн үндсэн ба туслах тоног төхөөрөмж, дамжлага нэг бүрийн аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага хангалт
- b. Ашиглалтанд ба бэлтгэлд байгаа өргөх, зөөх механизмуудын аюулгүй шаардлага хангалтын байдал
- c. Хэлтэс алба, тасагт буй тэсэрч дэлбэрэх, химийн хорт, галын аюултай бодисын материалын хадгалалт, ашиглалтын аюулгүйн шаардлага хангалтын байдал
- d. Тэсэрч дэлбэрэх, хордлого гарах, шаталт гал гарах нөхцөл байдал үүсч буй эсэхийг хянах, магадлах арга ажиллагаа, хянах дохиолох, сэргийлэх хэрэгсэл системүүдийн бүрэн бүтэн, найдвартай байдал
- e. Аюулгүй ажиллагааны нарядын системын мөрдөлт
- f. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөлтийн байдал
- g. Ажиллагсдын ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийн хангалт, хэрэглэлт
- h. Хэлтэс салбар дахь хөдөлмөрийн нөхцөлийн физик үзүүлэлтийн ерөнхий байдал
- i. Ахуйн байруудын ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл байдал

3. Хоёр дах шатны хяналтын хүрээнд хэлтэс алба, хэсэг, албадын хэмжээнд удирдлагаас албан ёсоор бичгээр өгөгдсөн бүхий л шийдвэр, даалгавар, акт, шаардлагын биелэлт болон өмнөх үзлэгээр илэрсэн зөрчил дутагдлыг арилгасан байдлыг дүгнэнэ.

4. Хоёр дах шатны хяналт явуулах хуваарь, хөтөлбөр явуулсан тухай протокол, илэрсэн дутагдал зөрчлийн жагсаалт, арилгах арга хэмжээний төлөвлөгөө зэргийг нэгтгэн алба хэлтэсийн дарга хадгална.

Дөрөв. Гуравдах шатны хяналт

1. Байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдлын зөвлөлийн гишүүд, захиргааны аппаратын болон дотоод хяналтын ажилтан нарын бүрэлдэхүүнтэй комисс томилон байгууллагынхаа хэмээнд ХАБЭА-н байдал, жилд нэгээс доошгүй удаа хийх шалгалтыг гуравдах шатны шалгалт гэнэ.

2. Гуравдах шатны хяналтаар дараах зүйлүүдийг шалгана.

- a. Хяналтын нэг, хоёрдугаар шатны ажлын тогтмолжилт, чанар, үр дүнг шалгаж үнэлгээ өгнө.
- b. Ослын актуудад заагдсан арга хэмжээнүүд, дээд байгууллагаас ирүүлсэн ослын тухай мэдээлэл-даалгавар зэргийн биелэлт гүйцэтгэлийг нэг бүрчлэн шалгаж дүгнэх
- c. Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар хамтын гэрээнд тусгагдсан арга хэмжээний гүйцэтгэлийг дүгнэж гаргах
- d. Байгууллагын болон цех, тасгуудын ХАБЭА-н талаарх жилийн ба хэтийн төлөвлөгөө, хөтөлбөрүүийн гүйцэтгэлийг дүгнэж гаргах
- e. Уурын ба усан халаатын зуу, даралтат сав, уур усны шугам хоолой, өргөх зөөх механизм, өндөр хүчдэлийн тоноглолын үзлэг, туршилт, сорилт, баталгаажуулалтын графикийн биелэлт, техникийн паспорт хөтлөлт баяжилтыг нэг бүрчлэн шалгах
- f. Үйлдвэрлэлийн аваар саатал, осол, галын аюулаас сэргийлэх, хяналт, дохиолол, хамгаалалтын хэрэгсэл системүүдийн туршилт шалгалтын графикийн биелэлт, баталгаажуулалт, найдвартай байдал
- g. Ажилчин, албан хаагч нарын ХАБЭА-н сургалт, дадлагажилт, мэдлэг чадварын шалгалт, аюултай нөхцөлд ажиллах эрх олголт

h. Үйлдвэрлэлийн үндсэн туслах тоноглол, барилга байгууламж, дамжлагуудаас сонголт хийх журмаар аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага, хөдөлмөрийн нөхцөл хаггалтанд шалгалт хийх

3. Гуравдугаар шатны хяналтын ажлыг 7 хоногийн эхнээс хуваарь хөтөлбөрийн дагуу явуулж, дүнгийн тухай илтгэл боловсруулан захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.